



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/03.

Мөрөн

Г Дотоод хяналтын багийг
шинэчлэн томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн дотоод хяналт шалгалтын багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч: А.Нандинцэцэг -эмчлэгч эмч

Гишүүд: Б.Алтантогос -сувилагч

Ч.Алтанзаяа- сувилагч

2. Эрүүл мэндийн төвийн дотоод хяналт шалгалт явуулах журмыг хавсралтаар баталсугай.

3. Дотоод хяналт шалгалтын нэгж нь хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, өөрийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүй хууль, журам, дүрэм, стандарт гэх мэт мэдээллийн сан бүрдүүлэн, хяналт шалгалтын ажлын үр дүн авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан, хамт олонд мэдээлэхээс гадна дотоод хяналт шалгалтын мэдээллийн сан бүрдүүлж ажиллахыг байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийн ахлагч (А.Нандинцэцэг) - т даалгасугай.

4. Дотоод хяналтын багийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллахыг багийн гишүүдэд үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан эрхлэгч эмчийн 2025 оны 01 дүгээр сарын 20 - ны өдрийн А/03 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЭРХЛЭГЧ

Б. Гандолгор

Б.ГАНДОЛГОР

2326010004
D.тушаал 2026

Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн
2026 оны 01 дүгээр сарын 20-ны
өдрийн 4/02 дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын журам

Нэг: Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журам нь эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү журам болон холбогдох хууль тогтоол, тушаал, эрх бүхий байгууллага, удирдлагын гаргасан дагаж мөрдөх шийдвэрүүдийг мөрдлөг болгоно.
- 1.3. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаан дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд энэ журам хамаарахгүй.

Хоёр: Дотоод хяналтын зарчим, зорилго хамрах хүрээ

- 2.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх хараат бус ил тод шударга бодитой хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.
- 2.2. Дотоод хяналт шалгалтын зорилго нь эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа иргэдэд үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь холбогдох хууль тогтоомжид нийцэж багй эсэх, гарсан зөрчил дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.
- 2.3. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж эрүүл мэндийн төвийн бүх үй ажиллагааг бүрэн хамарсан байн.

Гурав: Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах багийн ажлын эрх, үүрэг

- 3.1. Дотоод хяналтыг эрхлэгчийн тушаалаар томилогдсон ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ.
- 3.2. Дотоод хяналт, шалгалтын хэсэг нь эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд хийх хяналтыг тусгайлан төлөвлөгөө боловсруулж эрхлэгчээр батлуулж мөрдөн ажиллана.
- 3.3. Ажлын хэсэг баг нь эрхлэгчийн удирдлагад шууд захирагдах ба зохион байгуулалтын хувьд бусад нэгжээс хараат бус байна.

3.4. Дотоод хяналтын ажилтан нь өөрийн үндсэн ажлын байранд тогтвор суурьшилтай ажилладаг ажлын дадлага туршлагатай байна.

3.5. Дотоод хяналтын баг нь хяналт шалгалтын ажлын үр дүн авсан арга хэмжээний талаар улиралд нэг удаа эрүүл мэндийн төвийн удирдлагын хурлаар хэлэлцүүлж шаардлагатай бол шийдвэр гаргуулж хамт олонд мэдээлнэ.

3.6 Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын баг нь эрхлэгчийн баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт хийнэ.

3.7. Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын багийн үүрэг

3.7.1. Эрүүл мэндийн төвийн ДХБаг нь зохих удирдамж төлөвлөгөөний дагуу дотоод хяналт хийсэн дүнг тайлагнах

3.7.2. Дотоод хяналтын шалгалтыг хийхдээ холбогдох албан тушаалтантай шууд харилцан мэдээ, тайлан судалгаа гаргуулах, ажлыг шалгаж танилцах илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар гаргуулах

3.7.3. Илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчлийг арилгуулах дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах

3.7.4. Шаардлагат ай бол илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ноогдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх

3.7.5. Хууль тогтоомж, Ерөнхийлэгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах

3.7.6. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

3.7.7. Дотоод хяналтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах

3.7.8. Байгууллагын үйл ажиллагаанд учирч буй болзошгүй эрсдэл холбогдох хууль тогтоомж журам стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллийг удирдлагаар хангах

- 3.7.9. Хийсэн хяналтын талаар бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлэх
- 3.7.10. Энэхүү журмын 3.7-д заасан эрх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын баг, ажилтанд аливаа дарамт үзүүлэх үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв: Дотоод хяналт хийх үйл ажиллагаа

4.1. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна.

4.1.1. Хууль тогтоомж, Ерөнхийлэгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тухайн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд тавих хяналт шалгалт

4.1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавих

4.1.3 Өмчийн бүртгэл тооцоо ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих

4.1.4. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хийх хяналт

4.1.5. Хоол хүнсний үйлдвэрлэж байгаа болон боловсруулж байгаа байдал бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарт хяналт тавих

4.1.6. Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журам, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэнд хяналт тавих

4.1.7. Архив, бичиг хэрэг, албан бичгийн стандарт, АШМаягтын хөтлөлт, хадгалалт хамгаалалтанд хяналт хийх

Тав: Хариуцлага

5.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ноогдуулна.

5.2. Дотоод хяналтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.